



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 10 сарын 09 өдөр

Дугаар А/506

Мөрөн сум

Тусламж үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29.1.6-ийн “г” заалт, Төсвийн тухай хуулийн 14.2.3, 65.1.1 дэх заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны ээлжит XI хуралдааны 05 дугаар тогтоолыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мөрөн сумын 1 дүгээр багийн иргэн Ч.Алтанцэцэг, 8 дугаар багийн иргэн П.Сарантуяа, Б.Нямханд, Т.Энэбиш, Д.Байгалмаа, 9 дүгээр багийн иргэн Д.Сампилдондов, Б.Бадамдарь, Х.Норовсамбуу, 13 дугаар багийн иргэн Б.Загдсамбаржав, Д.Хөвсгөлсайхан, Л.Нацагням, Н.Төмөрхуяг, Ч.Оюунбилэг, Б.Цэрэндаш, 4 дүгээр багийн иргэн Н.Батхуяг, Т.Найданзул, Х.Дэмбэрэлноров, Н.Даваацэрэн, Д.Моломжамц нарын өргөдөл, хүсэлт, амьдралын боломж, байдлыг харгалзан үзэж, тус бүрт 100,000 төгрөгийн тусламж үзүүлсүгэй.

2. Дээрх иргэдэд олгох 1,900,000 төгрөгийн хөрөнгийг “Зорилтот бүлгийн иргэдэд нийгмийн хамгааллын үйлчилгээг үзүүлж, амьдрах орчныг сайжруулах” төсөл, арга хэмжээний зардлаас зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга Э.Аззаяа, Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Г.Базар/ нарт үүрэг болгосугай.

3.Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Х.Ган-Очир/-д даалгасугай.

ДАРГА



Л.ГАНБОЛД